**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2026/14/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Аудитор: Н.Хулансүрэн<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: Khulansurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.09 № 26

танай ________ -ны № ________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.ЦЭВЭЭНДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд давсан орлогоос санхүүжүүлэхээр нэлттэй сонгон шалгаруулалтаар сорилтын лабораторид 130,797.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан боловч нэмэлт санхүүжилтийг олгоогүйгээс өр төлбөрийн дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд гадаад тохирлын гэрчилгээ, цахилгааны ухаалаг тоолуурын баталгаажуулалт, улсын хэмжих хэрэгслийн тоолуурын баталгаажуулалт зэрэг орлогоос 1,498,241.2 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 2.6 дахин буюу 933,241.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4526050027

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 98.9 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **99,489,284.88** | **892,164,335.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **5,829,584.00** | **-** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 5,829,584.00 | - |
| 31210 | Төгрөг | 5,829,584.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 5,829,584.00 | - |
| **33** | **АВЛАГА** | **50,000,000.00** | **856,375,184.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 50,000,000.00 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 856,375,184.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **43,659,700.88** | **35,789,151.98** |
| 35100 | Түүхий эд материал | 33,628,600.88 | 19,464,756.98 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 9,665,000.00 | 9,665,000.00 |
| 35130 | Эм боох материал | 23,963,600.88 | 9,799,756.98 |
| 35400 | Хангамжийн материал | 10,031,100.00 | 16,324,395.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,306,100.00 | 2,169,695.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,050,000.00 | 1,050,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,675,000.00 | 13,104,700.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **959,403,784.12** | **1,058,622,508.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **959,403,784.12** | **1,058,622,508.67** |
| 39200 | Биет хөрөнгө | 738,853,784.12 | 949,472,508.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 589,828,645.48 | 609,728,645.48 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (121,285,953.06) | (145,228,773.01) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 19,800,000.00 | 19,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,980,000.00) | (3,960,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 317,598,806.00 | 572,448,426.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (111,346,301.65) | (145,286,365.37) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 47,477,967.50 | 55,050,447.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,818,713.51) | (18,033,871.85) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,830,000.00 | 24,830,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (13,250,666.64) | (19,876,000.12) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 220,550,000.00 | 109,150,000.04 |
| 39301 | Програм хангамж | 275,000.00 | 1,595,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (275,000.00) | (494,999.96) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 220,550,000.00 | 108,050,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **1,058,893,069.00** | **1,950,786,844.65** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **153,709,720.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **153,709,720.00** |
| 41300 | Өглөг | - | 153,709,720.00 |
| 41360 | Бусад өглөг | - | 153,709,720.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 147,289,720.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 6,420,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,058,893,069.00** | **1,797,077,124.65** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,058,893,069.00** | **1,797,077,124.65** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 424,122,327.31 | 424,122,327.31 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 424,122,327.31 | 424,122,327.31 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 271,064,861.66 | 1,009,248,917.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 277,460,024.85 | 271,064,861.66 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (6,395,163.19) | 738,184,055.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 363,705,880.03 | 363,705,880.03 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **1,058,893,069.00** | **1,950,786,844.65** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **1,479,274,903.03** | **2,273,401,318.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **413,081,653.03** | **2,273,401,318.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **413,081,653.03** | **1,612,479,991.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 401,452,530.00 | 1,448,241,201.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 393,164,240.00 | 1,448,241,201.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,088,290.00 | - |
| 120009 | Бусад орлого | 5,287,984.00 | 7,330,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,200,000.00 | 150,244,810.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 6,341,139.03 | 6,663,980.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **1,066,193,250.00** | **660,921,327.12** |
| **1221** | **Хандив тусламж дотоод** | **1,066,193,250.00** | **660,921,327.12** |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 578,419,000.00 | 502,549,100.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | 578,419,000.00 | 502,549,100.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 487,774,250.00 | 158,372,227.12 |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | - |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 120,535,100.00 | 158,372,227.12 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 357,239,150.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,485,170,066.38** | **1,422,717,262.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,485,170,066.38** | **1,422,717,262.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,151,077,852.19** | **1,297,149,907.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **694,239,913.68** | **869,383,033.36** |
| 210101 | Үндсэн цалин | 351,593,829.05 | 410,471,303.00 |
| 210102 | Нэмэгдэл | 263,785,317.27 | 329,012,430.36 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 39,658,216.70 | 76,140,000.00 |
| 210104 | Урамшуулал | 39,202,550.66 | 53,759,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,190,399.04** | **111,162,993.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 59,147,797.92 | 74,786,501.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 6,958,564.44 | 8,708,890.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 6,454,847.84 | 7,898,647.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 3,353,564.72 | 4,105,976.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 13,275,624.12 | 15,662,976.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,577,864.09** | **27,068,287.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,518,455.80 | 15,016,278.24 |
| 210302 | Түлш, халаалт | 12,401,912.37 | 9,220,250.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,657,495.92 | 2,831,758.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,271,446.00** | **33,332,942.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,309,350.00 | 13,839,635.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,550,000.00 | 5,948,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,007,700.00 | 3,385,232.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,508,135.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,787,340.00 | 1,955,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 6,696,540.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,617,056.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **47,899,151.74** | **53,615,263.90** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 35,976,031.74 | 51,310,563.90 |
| 210502 | Хоол, хүнс | 2,310,000.00 | 2,304,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,613,120.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **45,089,220.00** | **21,162,600.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 3,320,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 45,089,220.00 | 17,842,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **29,689,600.00** | **24,080,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,689,600.00 | 24,080,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **43,797,300.00** | **60,484,712.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,000,000.00 | 59,303,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 117,612.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 108,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,638,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 441,100.00 | 441,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 368,200.00 | 135,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **146,322,957.64** | **96,860,075.45** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 63,169,698.03 | 6,768,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,451,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 81,702,259.61 | 90,091,575.45 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **334,092,214.19** | **125,567,355.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **182,399,897.91** | **90,249,473.00** |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 182,399,897.91 | 90,249,473.00 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 182,399,897.91 | 90,249,473.00 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 41,684,337.91 | 15,249,472.00 |
| 2131122 | Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 140,715,560.00 | 75,000,001.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **149,096,239.00** | **33,352,282.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,468,400.00 | 20,252,282.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 56,875,229.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 79,752,610.00 | 13,100,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,596,077.28** | **1,965,600.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,596,077.28 | 1,965,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3=1-2)** | **(5,895,163.35)** | **850,684,055.65** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **499,999.84** | **112,500,000.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 499,999.84 | 112,500,000.00 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6=4-5)** | **(499,999.84)** | **(112,500,000.00)** |
| **7** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (7=3+6)** | **(6,395,163.19)** | **738,184,055.65** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **1,420,733,764.00** | **2,166,492,528.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **354,540,514.00** | **2,166,492,528.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **354,540,514.00** | **1,505,571,201.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 349,252,530.00 | 1,498,241,201.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 343,164,240.00 | 1,498,241,201.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,088,290.00 | - |
| 120009 | Бусад орлого | 5,287,984.00 | 7,330,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | **1,066,193,250.00** | **660,921,327.12** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **1,066,193,250.00** | **660,921,327.12** |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 578,419,000.00 | 502,549,100.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 578,419,000.00 | 502,549,100.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 487,774,250.00 | 158,372,227.12 |
| 122133 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 120,535,100.00 | 158,372,227.12 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 357,239,150.00 | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,393,934,480.00** | **2,151,102,112.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,393,934,480.00** | **2,151,102,112.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,059,842,265.81** | **1,169,159,573.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **694,239,913.68** | **859,684,249.00** |
| 210101 | Үндсэн цалин | 351,593,829.05 | 398,561,096.28 |
| 210102 | Нэмэгдэл | 263,785,317.27 | 329,626,352.72 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 39,658,216.70 | 76,045,463.00 |
| 210104 | Урамшуулал | 39,202,550.66 | 55,451,337.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **89,190,399.04** | **120,861,778.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 59,147,797.92 | 85,053,292.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 6,958,564.44 | 8,466,978.34 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 6,454,847.84 | 7,686,832.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 3,353,564.72 | 3,991,698.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 13,275,624.12 | 15,662,976.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,577,864.09** | **27,068,287.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,518,455.80 | 15,016,278.24 |
| 210302 | Түлш, халаалт | 12,401,912.37 | 9,220,250.16 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,657,495.92 | 2,831,758.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,614,740.00** | **12,867,677.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,483,600.00 | 2,799,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,550,000.00 | 4,490,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,007,700.00 | 2,831,632.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,508,135.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,573,440.00 | 1,238,660.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **53,746,200.00** | **35,733,270.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 46,460,200.00 | 30,321,170.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 2,310,000.00 | 1,912,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,976,000.00 | 3,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **43,880,050.00** | **27,754,900.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 4,984,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,880,050.00 | 22,770,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **29,689,600.00** | **17,960,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 29,689,600.00 | 17,960,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **44,429,100.00** | **54,706,212.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,000,000.00 | 53,459,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 117,612.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 108,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 30,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,638,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 441,100.00 | 441,100.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,000,000.00 | 550,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **65,474,399.00** | **12,523,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,493,399.00 | 12,523,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 981,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **334,092,214.19** | **981,942,539.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **2,596,077.28** | **946,624,657.00** |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 2,596,077.28 | 946,624,657.00 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 182,399,897.91 | 946,624,657.00 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | 41,684,337.91 | 15,249,472.00 |
| 2131124 | Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | 140,715,560.00 | 75,000,001.00 |
| 2131125 | Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | - | 856,375,184.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **149,096,239.00** | **33,352,282.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,468,400.00 | 20,252,282.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 56,875,229.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 79,752,610.00 | 13,100,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,596,077.28** | **1,965,600.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,596,077.28 | 1,965,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **26,799,284.00** | **15,390,416.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **32,011,300.00** | **21,220,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **32,011,300.00** | **21,220,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **32,011,300.00** | **21,220,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 32,011,300.00 | 21,220,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(32,011,300.00)** | **(21,220,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(5,212,016.00)** | **(5,829,584.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **11,041,600.00** | **5,829,584.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **5,829,584.00** | **-** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **424,122,327.31** | **363,705,880.03** | **278,310,483.58** | **-** | **1,066,138,690.92** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (850,458.73) | - | (850,458.73) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **424,122,327.31** | **363,705,880.03** | **277,460,024.85** | **-** | **1,065,288,232.19** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (6,395,163.19) | - | (6,395,163.19) |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **424,122,327.31** | **363,705,880.03** | **271,064,861.66** | **-** | **1,058,893,069.00** |
| D01 | **2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **424,122,327.31** | **363,705,880.03** | **271,064,861.66** | **-** | **1,058,893,069.00** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **424,122,327.31** | **363,705,880.03** | **271,064,861.66** | **-** | **1,058,893,069.00** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 738,184,055.65 | | 738,184,055.65 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **424,122,327.31** | **363,705,880.03** | **1,009,248,917.31** | **-** | **1,797,077,124.65** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,067,549,100.00** | **1,052,299,628.00** | **(15,249,472.00)** | **98.6** |
| **12** | **Татварын бус орлого** | **1,067,549,100.00** | **1,052,299,628.00** | **(15,249,472.00)** | **98.6** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **565,000,000.00** | **565,000,000.00** | **-** | **100.0** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 565,000,000.00 | 565,000,000.00 | - | 100.0 |
| **122** | **Тусламжийн орлого** | **502,549,100.00** | **487,299,628.00** | **(15,249,472.00)** | **97.0** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 502,549,100.00 | 487,299,628.00 | (15,249,472.00) | 97.0 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,067,549,100.00** | **1,052,299,628.00** | **(15,249,472.00)** | **98.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,067,549,100.00** | **1,052,299,628.00** | **(15,249,472.00)** | **98.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,046,296,800.00** | **1,031,047,346.00** | **(15,249,454.00)** | **98.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **723,732,300.00** | **723,732,300.00** | **-** | **100.0** |
| 210101 | Үндсэн цалин | 395,180,300.00 | 398,561,096.28 | 3,380,796.28 | 100.9 |
| 210102 | Нэмэгдэл | 203,836,300.00 | 193,674,403.72 | (10,161,896.28) | 95.0 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 69,264,400.00 | 76,045,463.00 | 6,781,063.00 | 109.8 |
| 210104 | Урамшуулал | 55,451,300.00 | 55,451,337.00 | 37.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **103,441,500.00** | **103,441,500.00** | **-** | **100.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,396,200.00 | 73,497,376.33 | (1,898,823.67) | 97.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,011,300.00 | 7,107,458.85 | 96,158.85 | 101.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,505,700.00 | 6,428,923.02 | 2,923,223.02 | 183.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,505,700.00 | 3,342,311.64 | (163,388.36) | 95.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,022,600.00 | 13,065,430.16 | (957,169.84) | 93.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,916,400.00** | **27,068,287.00** | **(1,848,113.00)** | **93.6** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,972,000.00 | 15,016,278.24 | 2,044,278.24 | 115.8 |
| 210302 | Түлш, халаалт | 12,453,000.00 | 9,220,250.16 | (3,232,749.84) | 74.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,491,400.00 | 2,831,758.60 | (659,641.40) | 81.1 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,560,900.00** | **12,867,677.00** | **(693,223.00)** | **94.9** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,605,100.00 | 2,799,250.00 | 194,150.00 | 107.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,500,000.00 | 4,490,000.00 | (1,010,000.00) | 81.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,225,000.00 | 2,831,632.00 | (393,368.00) | 87.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 957,300.00 | 1,508,135.00 | 550,835.00 | 157.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,273,500.00 | 1,238,660.00 | (34,840.00) | 97.3 |
| **2105** | **Нормативт зардал** | **45,122,900.00** | **35,733,270.00** | **(9,389,630.00)** | **79.2** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 39,318,200.00 | 30,321,170.00 | (8,997,030.00) | 77.1 |
| 210502 | Хоол, хүнс | 2,304,700.00 | 1,912,100.00 | (392,600.00) | 83.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,500,000.00 | 3,500,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **47,954,900.00** | **47,654,900.00** | **(300,000.00)** | **99.4** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,984,900.00 | 4,984,900.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 42,970,000.00 | 42,670,000.00 | (300,000.00) | 99.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **20,630,000.00** | **17,960,000.00** | **(2,670,000.00)** | **87.1** |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,630,000.00 | 17,960,000.00 | (2,670,000.00) | 87.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **56,354,700.00** | **56,006,212.00** | **(348,488.00)** | **99.4** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,459,500.00 | 53,459,500.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 348,400.00 | - | (348,400.00) | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 117,700.00 | 117,612.00 | (88.00) | 99.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 108,000.00 | 108,000.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 30,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,300,000.00 | 1,300,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 441,100.00 | 441,100.00 | - | 100.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 550,000.00 | 550,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,583,200.00** | **6,583,200.00** | **-** | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,583,200.00 | 6,583,200.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **21,252,300.00** | **21,252,282.00** | **(18.00)** | **100.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **21,252,300.00** | **21,252,282.00** | **(18.00)** | **100.0** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,252,300.00 | 20,252,282.00 | (18.00) | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **24.00** | **22.00** | **(2.00)** | **91.7** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 21.00 | 19.00 | (2.00) | 90.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 | - | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **158,372,227.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **158,372,227.12** |
| **122** | **Тусламжийн орлого** | **158,372,227.12** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **158,372,227.12** |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 158,372,227.12 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 158,372,227.12 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **158,372,227.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **158,372,227.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **156,372,227.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **135,951,949.00** |
| 210102 | Нэмэгдэл | 135,951,949.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **17,420,278.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,555,915.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,359,519.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,257,909.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 649,386.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,597,546.68 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 157,443.1 мянган төгрөгийн 1 алдааг[1] аудитын явцад залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны хэсэгт 110,535.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг данс хооронд зөрүүлэн бүртгэсэн, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 46,908.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалт, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 5.3, 5.6 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн *"Толилуулга"* батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланг залруулав.

Мөн илэрсэн 61.6 мянган төгрөгийн зөрчил[2]-д 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

### 3.1 Албан шаардлага

- Тайлант онд төсвийн тодотголоор нэмэгдүүлсэн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зардалд зарцуулсан нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.4 дэх заалт, санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

*<u>Илрүүлэлт:</u>*

Тайлант онд 1 албан хаагчид 35.9 мянган төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдлийг, 1 албан хаагчид 25.7 мянган төгрөгийн зэргийн нэмэгдлийг тус тус илүү тооцож олгосон нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 тогтоолоор баталсан хувь хэмжээгээр орон нутгийн нэмэгдлийг, Дархан-Уул аймгийн засаг даргын зэрэг дэвийн нэмэгдэл олгох захирамжилд заасан хэмжээгээр албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдлийг тус тус тооцож, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянаж баталгаажуулж байх,

[1] *Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,*

[2] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны хэсэгт 110,535.1 мянган төгрөгийн Нэмэлт санхүүжилтийн орлогыг данс хооронд зөрүүлэн бүртгэсэн, Нийт цэвэр мөнгөн гүйлгээг 46,908.1 мянган төгрөгөөр илүү тусгасан байна. | 1 | 157,251.6 | - | - | 1 | 157,251.6 | 1 | 157,251.6 | - | - | - | - |
| **Дүн** | 1 | **157,251.6** | - | - | 1 | **157,251.6** | 1 | **157,251.6** | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орон нутагт ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон 1 албан хаагчид 35.9 мянган төгрөг, зэргийн нэмэгдлийг илүү тооцож олгосон 1 албан хаагчид 25.7 мянган төгрөгийг тус тус илүү олгосон байна. | 1 | 61.6 | - | - | - | - | 1 | 61.6 | - | - | - | - |
| Тайлант онд төсвийн тодотголоор нэмэгдүүлсэн 13,650.0 мянган төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зардлыг санхүүжүүлсэн байна. | 1 | - | - | | 1 | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **61.6** | **-** | **-** | **1** | **-** | **1** | **61.6** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд 2 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 17,848.9 | - | - | 1 | 17,848.9 | - | - |
| **Дүн** | **1** | **17,848.9** | - | - | **1** | **17,848.9** | - | - |